



МОНГОЛ-ОРОС-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР БАЙГУУЛАХ ХӨТӨЛБӨР

Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс /цаашид "Талууд" гэх/,

Уламжлалт найрсаг харилцан ашигтай эдийн засгийн харилцааг хөгжүүлэх нь Талуудын гадаад бодлогын стратегийн чиглэлийн нэг хэмээн үзэж,

Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Уфа хотноо гарын үсэг зурсан Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр боловсруулах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу,

"Талын зам" санаачилга, Евразийн эдийн засгийн холбоо болон Торгоны замын эдийн засгийн бүсийн бүтээн байгуулалтыг уялдуулахыг харгалзан үзэж,

Эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг баримталж,

Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах энэхүү хөтөлбөрийг боловсруулав (цаашид "Эдийн засгийн коридор" гэх).

1. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Эдийн засгийн коридор байгуулах зорилго нь Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнийг өрсөлдөх чадвараар хангах, хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийг хөгжүүлэхэд

чиглэсэн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх замаар гурван талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх нөхцлийг хангахад оршино.

Эдийн засгийн коридорын хэтийн төлөв нь Тал тус бүрийн боломж, давуу талыг ашиглах, тэдгээрийн хөгжил цэцэглэлтэд болон дэлхийн зах зээл дээр хамтын өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд нөлөөлөх хамтарсан харилцан ашигтай эдийн засгийн хөгжлийн орон зайг бүрдүүлэх болон бэхжүүлэх явдал юм.

Талууд Эдийн засгийн коридорыг байгуулахыг дэмжснээр бүс нутгийн эдийн засгийн интеграцчлалыг гүнзгийрүүлэх, хөгжлийн стратегийг уялдуулах болон дэд бүтцийн харилцан холбогдох нөхцлийг бүрдүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг тогтвортой болон дэвшилттэй хөгжүүлэх, түүнчлэн эдийн засгийн бодлогыг харилцан зохицуулах, хүмүүнлэгийн харилцаа, холбоог бэхжүүлэхэд түлхэц болно гэдэгт итгэж байна.

Талууд хамтарсан төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх нөхцлийг бий болгох зорилгоор олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны төрөл бүрийн талбарыг идэвхтэй ашиглана.

2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хүрээнд дараахь салбар чиглэлийн хамтын ажиллагаа хамаарна. Үүнд:

(I) Тээврийн дэд бүтцийн харилцан уялдаа бүхий хөгжлийг дэмжих

Монгол, Орос, Хятадын авто зам болон төмөр зам, агаарын тээвэр, далайн боомт, хилийн боомтын дэд бүтцийн нөөц боломжийн хөгжлийг харилцан уялдаатай төлөвлөх, Талуудын олон улсын зам, тээврийн харилцаа, хил орчмын дэд бүтэц болон хил дамнасан тээвэрлэлтийг зохион байгуулах хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцааны байнгын механизмыг бүрдүүлэх, Хятад-Орос, Ази-Европ хоорондын дамжин өнгөрөх тээврийг цаашид хөгжүүлэх зорилгоор тээврийн дэд бүтцийг харилцан уялдуулан холбоход дэмжлэг үзүүлнэ.

- Олон улсын хуурай замын тээврийн коридоруудыг бий болгох болон хөгжүүлж, зорчигч, бараа болон тээврийн хэрэгслийн саадгүй хөдөлгөөнийг хангах зорилгоор дэд бүтцийн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлнэ;

- Талуудын төмөр зам, авто замын дамжин өнгөрөх тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлж, тэр дундаа одоо байгаа төмөр зам, авто замыг шинэчлэх бөгөөд шинээр төмөр зам, авто замыг бүтээн байгуулна;
- Хил дамнасан тээврийн салбарт технологийн болон тарифын таатай нөхцөл, дүрмийг зөвшилцөн боловсруулж, хил, гаалийн хяналт, шилжүүлэн ачилт, олон төрөлт тээвэрлэлтийн үйл ажиллагааны нэгдсэн уялдааг бий болгон, олон улсын холимог тээвэрлэлтийн мэдээллийг солилцоход дэмжлэг үзүүлж, төмөр замын тээвэрлэлттэй холбоотой баримт бичгийг, тэр дундаа урьдчилсан мэдээллийг цахим хэлбэрээр солилцох нөхцлийг бүрдүүлнэ;
- Талуудын агаарын навигацийн үйлчилгээг харилцан уялдаатай хөгжүүлж, аюулгүй байдал, эдийн засгийн үр ашиг болон агаарын орон зайг ашиглах давтамжийг нэмэгдүүлнэ;
- Талууд хоорондын байнгын үйл ажиллагаатай олон улсын чингэлгийн тээврийг хөгжүүлж, тээвэр-логистикийн зангилааг бүтээн байгуулна.

(II) Хилийн боомтуудыг хөгжүүлэх, гаалийн болон хорио цээрийн хяналтыг боловсронгуй болгох

- Материал-техникийн хангамжийг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргаж, Талуудын хилийн боомтын дэд бүтцийг сэргээн засварлах болон шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ, мөн хилийн боомт дахь урьдчилан сэргийлэх болон эрүүл ахуйн хяналтын түвшин, мэдээлэл харилцан солилцох түвшин, мөн түүнчлэн хууль сахиулах салбарт харилцан туслалцах түвшинг тус тус нэмэгдүүлж, шалган нэвтрүүлэх цэгээр нэвтэрч буй бараанд тавих гааль, хорио цээрийн үйл ажиллагаа болон хяналтын үр дүнг дээшлүүлэх зорилгоор хамтын ажиллагааны шинэ механизм, хэлбэрийг бий болгож, бүх хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлнэ;
- Хилийн төмөр замын өртөөдийн ачаа шилжүүлэн ачих, боловсруулах хүчин чадал болон төмөр замын хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг тэнцвэртэй нэмэгдүүлнэ;

- Мал эмнэлгийн болон ургамал хорио цээрийн хяналтын чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлнэ;
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтын ажиллагааны механизмыг бий болгож, Талуудын хүнсний бүтээгдэхүүний хил дамнасан худалдаанд тавих хяналтын салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлж, хүнсний бүтээгдэхүүний хил дамнасан худалдааны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ;
- Талууд дадлага, туршлага, тэр дундаа Эдийн засгийн итгэмжлэгдсэн операторын тогтолцоог хэрэгжүүлэх салбарт туршлага дэлгэрэнгүй солилцож, харилцан уялдаа холбоог бэхжүүлнэ;
- Хил дамнасан халдварт өвчний хяналт шинжилгээ ба шалгалт, халдвар тээгчийн хяналт шинжилгээ, олон нийтийн эрүүл мэндийн салбарт онцгой байдал үүсэхэд хариу арга хэмжээ авах зэрэг салбарт хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

(III) Аж үйлдвэр болон хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааг бэхжүүлэх

Талуудын эрчим хүчний эрдэс баялгийн нөөц, өндөр технологи, үйлдвэрлэл, газар тариалан, ойн болон мал аж ахуй зэрэг салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадал болон хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааны кластеруудыг хамтран байгуулах, аж үйлдвэрийг харилцан уялдаатай хөгжүүлэх, нягт харилцан уялдаа холбоотой бүс нутгийн үйлдвэрлэлийн сүлжээг байгуулна.

- Талууд хоорондын цахим мэдээллийн сүлжээг өргөжүүлж, интернетийн урсгалыг болон цахим худалдааны хэмжээг нэмэгдүүлж, дамжин өнгөрөх урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар судална;
- Цахилгаан дамжуулах шинэ шугам барих болон эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг байгуулах техникийн болоод эдийн засгийн үндэслэлийг судална;
- Тодорхой санал гарсан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах

Хятад Ард Улс руу газрын тос болон хий дамжуулах хоолой барих эдийн засгийн үндэслэлийг судална;

- Цөмийн эрчим хүч, усны эрчим хүч, салхи болон нарны эрчим хүч, био эрчим хүчний салбарт Талуудын хамтын ажиллагааг үргэлжлүүлнэ;
- Технологийн парк болон инновацийн бүсийн салбарт Талуудын хамтын ажиллагааг бэхжүүлнэ;
- Иргэний сансарын дэд бүтцэд тулгуурлан хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэх болон Талуудын тус салбар дахь мэргэжилийн хамтын ажиллагааг өрнүүлж, мэдээллийн солилцоо, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

(IV) Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх

Хил орчмын худалдааг тогтвортой хөгжүүлж, худалдааны эргэлтийн бүтцийг сайжруулах, үйлчилгээний худалдааны цар хүрээг өргөжүүлэхийг хөхиүлэн дэмжих, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хамрах салбарын хүрээг өргөжүүлэх, түвшинг дээшлүүлнэ.

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, эрчим хүчний эрдэс баялгийн нөөц, барилгын материал, түүнчлэн модон болон цаасан бүтээгдэхүүн, нэхмэл эдлэлийн худалдааны хэмжээг өргөжүүлэхийн зэрэгцээ тоног төхөөрөмж болон өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түвшинг тогтвортой өсгөнө;
- Аялал жуулчлал, логистик, санхүү, зөвлөх үйлчилгээ, зар сурталчилгаа, соёл урлаг, уран бүтээл туурвил зэрэг үйлчилгээний худалдааны салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлж; мэдээллийн технологи, үйлдвэрлэлийн үйл явц болон ноу-хау)-гийн аутсорсингийг дэмжиж, программ хангамжийн боловсруулалт болон тоон мэдээллийн хамгаалалтын салбарт хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ;
- Эдийн засгийн хамтын ажиллагааны хил дамнасан чөлөөт бүсийг байгуулна;
- Хил орчмын худалдааг дахин боловсруулалт, хөрөнгө оруулалт болон худалдааны салбарт интеграцчлах чиглэлд боловсронгуй болгоно.

(V) Хүмүүнлэгийн солилцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх

Боловсрол, шинжлэх ухаан, техник, соёл, аялал жуулчлал, эрүүл мэнд, оюуны өмчийн салбарт хамтын ажиллагааг нэн тэргүүнд гүнзгийрүүлэх, иргэд харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлэх, төрийн бус харилцаа, холбоо, солилцоог өргөжүүлнэ.

- Аялал жуулчлалыг хөгжүүлж, хил дамнасан бүс нутаг хоорондын аялал жуулчлалын маршрутыг бий болгоно;
- Аялал жуулчлал, амралт сувилалын чадавхийг боловсронгуй болгож, аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, Талуудын хил орчмын хотуудад хүртээмжтэй, тав тухтай аялал жуулчлалын орчныг бүрдүүлнэ;
- Хил дамнасан бүс нутаг хоорондын аялал жуулчлалд оролцогчдын аюулгүй байдлыг цогц байдлаар хангах хүрээнд жуулчдын хувийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, мөн аяллын үед Талуудын байгаль орчинд хохирол үл учруулах нөхцлийг хангах арга хэмжээ бүхий тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлж; онцгой байдлын үед жуулчдад тусламж үзүүлэх механизмыг бий болгоно;
- Аялал жуулчлалын хамтарсан брэнд боловсруулах болон жуулчдыг мэдээллээр хангах нэгдсэн арга барилтай болох боломжийг судлана;
- Боловсрол, эрдэм шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлнэ;
- Оюуны өмчийн салбар дахь эрх зүйн зохицуулалт, эрхийг хамгаалах практик, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр Талууд хамтын ажиллагаа, солилцоог бэхжүүлнэ;
- Соёлын солилцооны брэнд бий болгох, урлагийн салбарт шууд харилцаа холбоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, театр, дуу хөгжим, циркийн болон кино урлаг, ардын урлаг, соёлын өвийн хамгаалал, номын сан, түүнчлэн соёлын салбарын боловсон хүчин бэлтгэх талаар хамтын ажиллагаа, харилцаа холбоог гүнзгийрүүлнэ.

(VI) Хүрээлэн буй орчныг хамгаалах, экологийн салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх

- Мэдээллийг хамтран ашиглах “талбар” байгуулах боломжийг судалж, биологийн төрөл зүйл болон байгаль орчны тусгай хамгаалалттай бүс, ус, намгархаг газрыг хамгаалах, ойг гал түймрээс хамгаалах, цөлжилттэй тэмцэх зэрэг салбарт хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ;
- Байгалийн гамшгийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, экологийн гамшиг болон технологийн гаралтай осол, хил дамнасан ой, хээрийн түймэр, гоц халдварт өвчин, байгалийн аюултай үзэгдлийн үед үр дүнтэй мэдээллийн солилцоог зохион байгуулна;
- Хүрээлэн буй орчныг хамгаалах, экологийн салбар дахь техникийн солилцоо, хамтын ажиллагааг идэвхитэй хөгжүүлнэ;
- Хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлаар семинар хамтран зохион байгуулж, судалгаа, туршилт-шинжилгээний салбарт хамтран ажиллах боломжийг судлана.

(VII) Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэх

Бүс нутгийн харьцангуй давуу талыг бүрэн нээж, бүс нутаг болон хил орчмын хамтын ажиллагааг ахиулж, бүс нутгийн хамтын ажиллагааны нээлттэй “талбарыг” бий болгож, Эдийн засгийн коридор байгуулахад Талуудын бүс нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг цаг тухайд нь бэлтгэнэ.

- Монгол, Орос, Хятадын бүс нутаг хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг ахиулна;
- Талуудын холбогдох хотуудын харьцангуй давуу талыг бүрэн нээж, хамтын ажиллагааны механизмыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ, тухайлбал, Монгол Улсын зүүн аймгууд болон БНХАУ, ОХУ-ын холбогдох бүс нутгийг оролцуулсан монгол-орос-хятадын бүс нутаг хоорондын хамтын ажиллагааны механизм.

3. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Тал тус бүрийн тодорхойлсон газар зүйн хязгаарын дотор Талуудын хэлэлцэн тохиролцсон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрт хамрагдсан төслүүдийн санхүүжилтийг төр, хувийн хэвшил, төр-хувийн хэвшлийн түншлэл, мөн түүнчлэн олон улсын санхүүгийн байгууллагуудын эх үүсвэрээс, түүний дотор, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүйгээр, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, БРИКС-ийн Хөгжлийн шинэ банк, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын Банкны нэгдэл, Торгоны замын сан зэрэг санхүүгийн байгууллагын санхүү-хөрөнгө оруулалтын дэмжлэгээр тухай бүрт нь тусгайлан тохиролцсоны дагуу хэрэгжүүлнэ.

5. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕХАНИЗМ

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан ажиллах Талуудын гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллагууд нь:

- монголын талаас - Монгол Улсын Гадаад хэргийн яам;
- оросын талаас - Оросын Холбооны Улсын Эдийн засгийн хөгжлийн яам;
- хятадын талаас - Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөгжил, шинэчлэлийн хороо байна.

Талуудын харилцан тохиролцсон төслийн жагсаалт нь энэхүү Хөтөлбөрийн Хавсралт байх бөгөөд Талууд харилцан тохиролцсоноор төслийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Талуудын эрх бүхий байгууллагууд энэхүү Хөтөлбөр болон төслүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, мөн түүнчлэн тэдгээрийг цаашид хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тохиролцох зорилгоор жилд нэгээс багагүй удаа уулзалт зохион байгуулна.

Талууд төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг бэлтгэх зорилгоор хөрөнгө оруулалтын зураг төслийн хамтарсан төвийг байгуулах боломжийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд тус төвийг байгуулна.

6. БУСАД

Энэхүү хөтөлбөр нь олон улсын гэрээ биш бөгөөд олон улсын эрх зүйгээр зохицуулах эрх, үүргийг үүсгэхгүй ба Талуудын олон улсын гэрээгээр эдлэх эрх, хүлээх үүргийг үл хөндөнө.

Энэхүү хөтөлбөр нь түүнд Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш таван жилийн хугацаанд хэрэгжинэ.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуусгавар болсны дараа түүний биелэлтийг хамтран дүгнэх бөгөөд биелэлтийн үр дүнгээс хамаарч Талууд харилцан тохиролцсоноор Хөтөлбөрийн хэрэгжих хугацааг дахин таван жилээр сунгаж болно.


Энэхүү хөтөлбөрийг Ташкент хотноо 2016 оны 6 дугаар сарын “ ”-ны өдөр монгол, орос, хятад хэлээр тус бүр гурван хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

Хавсралт: Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах төслийн жагсаалт


МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ:



ОРОСЫН ХОЛБООНЫ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:



БҮГД НАЙРАМДАХ
ХЯТАД АРД УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ:



**МОНГОЛ-ОРОС-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР БАЙГУУЛАХ
ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

№	Төсөл, арга хэмжээ
	<u>Тээврийн дэд бүтэц</u>
1.	Төмөр замын Төв коридор (Улаан-Үд – Наушки – Сүхбаатар – Улаанбаатар - Замын-Үүд – Эрэн – Улаанцав – Жанчхүү – Бээжин - Тяньжин)-ыг иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах эдийн засгийн үндэслэлийг судлах
2.	Төмөр замын Хойд коридор (Курагино – Кызыл - Цагаан толгой - Арц суурь – Овоот – Эрдэнэт – Салхит - Замын-Үүд – Эрэн – Улаанцав – Жанчхүү – Бээжин - Тяньжин)-ын төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх
3.	Төмөр замын Баруун коридор (Курагино – Кызыл - Цагаан толгой - Арц суурь – Ховд – Такашикэн - Хами муж - Цонжийн хотон үндэстний өөртөө засах тойрог - Өрөмч)-ын төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх
4.	Төмөр замын Зүүн коридор (Борзя – Соловьевск – Эрэнцав – Чойбалсан – Хөөт – Бичигт - Шилийн гол (Зүүн хатавч) – Улаанхад – Чаоян - Жиньжоу/Паньзинь)-ын төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх
5.	“Түмэн голын тээврийн коридор” (“Далайн эрэг-2”) (Чойбалсан – Сүмбэр – Рашаан – Улаанхот – Чанчунь – Яньзи – Хуньцунь - Зарубино)-ыг өргөжүүлэх төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх
6.	Төмөр замын тээврийн “Далайн эрэг-1” коридор (Чойбалсан - Сүмбэр – Рашаан – Манжуур – Цицихар – Харбин – Муданьзян – Суйфэньхө – Владивосток - Находка)-ыг өргөжүүлэх төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх
7.	Москва - Бээжин чиглэлийн өндөр хурдны төмөр замын шугамыг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих хэтийн боломжийг судлах
8.	Гурван талын логиستيкийн компани байгуулах асуудлаар хамтарсан яриа хэлэлцээ өрнүүлэх
9.	Азийн автозамын сүлжээний АН-3 (Улаан-Үд – Хиагт/Алтанбулаг – Дархан – Улаанбаатар – Сайншанд - Замын-Үүд/Эрэн – Бээжингийн гаднах тойрог – Тяньжин) чиглэлийг дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах, тус чиглэлд хурдны автозам барих эдийн засгийн үндэслэлийг судлах

10.	Азийн автозамын сүлжээний АН-4 (Новосибирск – Барнаул - Горно-Алтайск – Ташанта/Улаан байшинт – Ховд-Ярантай/Такашикэн – Өрөмч – Каши – Хонкираф) чиглэлийг бүтээн байгуулж, дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах
11.	Автозамын Зүүн коридор (Борзя - Соловьевск - Эрэнцав – Чойбалсан – Баруун Урт – Бичиг – Зүүнхатавч – Си - Уджимчин-Ци – Улаанхад/Шилийн хот – Чаоян/Чэндэ - Жиньжоу/Паньзинь/Тяньжин чиглэлд)-ын төслийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх
12.	Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэр гүйцэтгэх тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (АНДЭЗНЖ)
13.	Харилцаа холбооны дэд бүтцийг байгуулах ажлыг илүү идэвхжүүлж, Улаан-Үд – Хиагт/Алтанбулаг - Дархан - Улаанбаатар - Сайншанд - Замын-Үүд/Эрэн - Улаанцав - Бээжин - Тяньжин чиглэлийн дамжин өнгөрөх тээврийн коридоруудын технологийн үйл ажиллагааг удирдах, аюулгүй байдлыг хангах талбарыг байгуулах
	Аж үйлдвэрийн салбар дахь хамтын ажиллагаа
14.	Монгол, Орос, Хятадын Эдийн засгийн коридорын тэргүүний жишиг бүсийг байгуулах ажлыг эрчимжүүлэх, гурван улсын хоорондын үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны кластерийг байгуулах боломжийг судлах
15.	Хейлунжин муж (БНХАУ), Оросын Холбооны Улсын холбогдох субъект, Өвөр Монголын Өөртөө Засах Орон (БНХАУ), Монгол Улсын хооронд эдийн засгийн хамтын ажиллагааны жишиг бүс байгуулах үндэслэлийг судлах
	Хилийн боомтыг шинэчлэх
16.	ОХУ-ын төмөр замын Забайкальск, авто замын Пограничный, Краскино, Монд хилийн боомтыг сэргээн засварлах, БНХАУ-ын Манжуур, Суйфэньхэ, Хуньчунь, Эрээний хилийн боомтыг шинэчлэх, Монгол Улсын төмөр зам, авто замын боомтуудыг шинэчлэх, бүтээн байгуулах
	Эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа
17.	Монгол, Оросын цахилгаан эрчим хүчний сүлжээг шинэчлэхэд Хятадын аж ахуйн нэгжүүд оролцох боломжийг судлах
	Худалдаа, гааль, мэргэжлийн хяналт шалгалт, хорио цээрийн салбар дахь хамтын ажиллагаа
18.	2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол, Орос, Хятадын хилийн боомтын хөгжлийн салбарт хамтран ажиллах тухай Ерөнхий хэлэлцээр болон Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гаалийн албад хооронд Гурван улсын хоорондын худалдааны хөгжлийг дэмжих таатай нөхцөл бүрдүүлэх талаар хамтран ажиллах тухай Санамж бичгийг хэрэгжүүлэх

19.	Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Гааль, татварын ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Холбооны гаалийн алба, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын Хэлэлцээр байгуулахыг дэмжиж, хэрэгжүүлэх
20.	“Бүс, зам” санаачилгын хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын салбар дахь хамтын ажиллагааны тухай Монгол, Орос, Хятадын 2015 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн Хамтарсан мэдэгдлийг хэрэгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний хил дамнасан худалдааны хяналтын хамтын ажиллагааг бэхжүүлэн, худалдааны нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
21.	Монгол Улс, ОХУ-ын эрх бүхий байгууллагууд болон БНХАУ-ын Чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн ерөнхий газрын хоорондын хамтын ажиллагааны Ерөнхий хэлэлцээрүүдэд гарын үсэг зурахад дэмжлэг үзүүлэх, үүнд: хилээр нэвтрэх /орж гарах/ амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний хорио цээрийн салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх, хил дамнасан мал, ургамлын гоц халдварт өвчин, хортой биологийн тархалтаас урьдчилан сэргийлэх, мал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний худалдааны аюулгүй байдлыг хангах
	<i>Хүрээлэн буй орчныг хамгаалах болон экологийн салбар дахь хамтын ажиллагаа</i>
22.	Байгалийн тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлээрх гурван талын харилцан ашигтай хамтын ажиллагааг хангах практик хамтын ажиллагааг эрчимжүүлэх, холбогдох харилцаа холбоог бэхжүүлэх, зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах, Монгол, Орос, Хятадын хамтарсан “Дагуурын” дархан цаазат газрын үйл ажиллагааны хүрээнд харилцан ашигтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх
23.	Монгол-Орос-Хятадын хил дамнасан экологийн коридоруудыг байгуулах, зэрлэг ургамал болон амьтны аймаг, ус, намгархаг газартай холбогдох эрдэм шинжилгээний хайгуул, хяналт шинжилгээ хийж, зэрлэг ан амьтан, ургамал, нүүдлийн шувуудыг хамгаалах салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх
24.	Хүрээлэн буй орчныг хамгаалах болон экологийн салбарт хамтарсан удирдлагын болон мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох боломжийг судлах, түүнчлэн байгаль орчныг хамгаалах сэдвээр семинар зохион байгуулах
	<i>Шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа ба боловсрол</i>
25.	Гурван улсын шинжлэх ухаан, техникийн парк, инновацийн талбар хоорондын, мөн түүнчлэн эрдэм шинжилгээний болон боловсролын байгууллагуудын хооронд тээвэр, хүрээлэн буй орчныг хамгаалах болон байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалт, амьдрахуйн шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологи, нано систем ба материал, эрчим хүч, эрчим хүчийг хэмнэх ба хог хаягдлыг бууруулах, хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, аж үйлдвэрийн шинэ технологи, байгалийн болон технологийн гаралтай гамшигийн зэрэг салбарт хамтын ажиллагааг бэхжүүлэх

26.	Талуудын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тухай мэдээллийн солилцоог урагшлуулж, эрдэм шинжилгээний ажилтнуудыг солилцох, дадлагжуулахад дэмжлэг үзүүлэх
27.	Сурагчдын харилцан солилцоо болон оюутнуудыг гадаадад харилцан суралцуулах хүрээг өргөжүүлэх. Боловсролын байгууллагуудын нөөц бололцоонд тулгуурлан залуучуудын боловсролын солилцоог урагшлуулах
	<i>Хүмүүнлэгийн хамтын ажиллагаа</i>
28.	Хил дамнасан бүс нутаг хоорондын аялал жуулчлалын чиглэлүүдийг хөгжүүлэх, тухайлбал, Монголын Хөвсгөл нуур, Оросын Байгаль нуур, Хятадын Хөлөнбуйр нуурыг оруулсан "Их нууруудын гурвалжин", мөн түүнчлэн Монгол-Орос-Хятадын аялал жуулчлалын тойргийг бий болгох
29.	Монгол-Орос-Хятадын олон улсын аялал жуулчлалын "Цайны их зам" брэндийг бий болгох
30.	Гурван улсын киноны арилжааны солилцоог урагшлуулах, хамтарсан кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх
	<i>Хөдөө аж ахуй</i>
31.	Хамтран ажиллах эрмэлзлэлийн тухай Монгол Улсын Мал эмнэлэг, үржлийн газар, ОХУ-ын Мал эмнэлэг, ургамал, хорио цээрийн хяналтын Холбооны алба болон БНХАУ-ын Мал эмнэлгийн алба хоорондын 2015 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн Протоколыг хэрэгжүүлэх
	<i>Анагаах ухаан, эрүүл мэндийг хамгаалах салбар</i>
32.	Анагаах ухаан болон эрүүл мэндийг хамгаалах олон улсын семинар хамтран зохион байгуулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах салбарт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх